



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 59,466,000.00 (тавин есөн сая дөрвөн зуун жаран зургаан мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Анхбаяр, Хилийн цэргийн 0108 дугаар ангийн захирагч, хурандаа В.Намхайнямбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000111

4-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ХИЛИЙН ЦЭРГИЙН 0108 ДУГААР АНГИД БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын болон арлын дугаар.	Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)
1	Тоёото ланд крузер-78, арлын дугаар JTERB71J800060802, улсын дугаар 4900 УНР	2011	140,000	59,466,000.00	3.00	30,000,000.00
НИЙТ ДҮН				59,466,000.00		30,000,000.00
				(тавин есөн сая дөрвөн зуун жаран зургаан мянга)		(гучин сая)